


1.0. Ойлголт

Сургалтын орчин гэсэн модуль нь **байр** болон **өрөөний** мэдээллийн хэсгийн бүртгэлийг хөтөлдөг.

Байрны мэдээлэл нь тухайн сургуулийн барилгын ерөнхий мэдээллийг агуулах бөгөөд үүнд Стандартын эсэх, ашиглаж байгаа эсэх, актлагдсан эсэх, эзэмшлийн төрөл, хүчин чадал, анхны өртөг, сүүлийн өртөг, хаяг гэх мэт мэдээллийг харуулна.

Өрөөний мэдээлэл нь өрөөний төрөл, танхимын төрөл, гэрчилгээтэй эсэх, багтаамж, эд хогшил, бүрэлдэхүүнтэй эсэх мэдээллийг оруулна.



1.1. Шинэ байр бүртгэх

1.1. Шинэ байр бүртгэх

Цонхны баруун талд байрлах скролыг гүйлгэж мэдээллийг бүрэн бөглөх боломжтой.

Анхаарах нь:

- *Байр*
- *Хэрэв тухайн 1 байрыг олон зориулалтаар ашигладаг бол үндсэн зориулалт талбарт гол зориулалтыг сонгоод бусад зориулалтыг нэмэлт зориулалт хэсэгт нэмж бүртгэх*
- *Засвар үйлчилгээ хэсэгт их засвар хийсэн түүх, урсгал засварын түүхийг бүртгэх*
- *Дэд бүтэц хэсэгт халаалт, инженерийн шугам сүлжээ, эрчим хүчний мэдээллийг бүртгэх*

Шинэ байр үүсгэх
Хадгалах

Байрны код: 10000285492271

Стандартын эсэх:

Байрны нэр: Хичээлийн 1-р байр

Байрны хүчин чадал (Норм): 900

Байрны хүчин чадал (Ашиглаж байгаа): 900

Андги танхимын тоо (Норм): 30

Андги танхимын тоо (Ашиглагдаж байгаа): 36

Барилгын анхны өртөг (Төгрөгөөр): 596,854,200.00

Барилгын одоогийн үнэлгээ (төгрөгөөр): 1,526,450,000.00

Акталсан эсэх:

Ашиглаж байгаа эсэх:

Тайлбар: Стандартын бус байр

Нэмэлт зориулалт

Зориулалт	Байрын хүчин чадал (Ашиглагдаж байгаа)	Андги, танхимын тоо (Ашиглагдаж байгаа)
Хичээлийн байр	900	36
Гал тогооны байр	50	2

Засвар үйлчилгээ

Төрөл	Эхэлсэн өдөр	Дууссан өдөр	Нийт өртөг (төгрөгөөр)	Гүйцэтгэгч байгууллага
Өргөтгөл	2014-09-01	2014-11-03	56,451,200.00	Их орд ХХК
Их засвар	2012-08-01	2012-10-01	15,245,020.00	Баян ХХК

Дэд бүтэц /Төрөл тус бүрээр мэдээллийг бүртгэнэ үү/

Төрөл	Хэлбэр	Түлшний төрөл	Уурын зуухны амны тоо
Интернет	Шилэн кабель		
Халаалт	Төвлөрсөн халаалт		
Инженерийн шугам сүлжээ	Төвлөрсөн инженерийн шугам		
Эрчим хүч	Төвлөрсөн эрчим хүч		

Хаяг байршил

Улс: Монгол

Хаягийн төрөл: Байгууллага

Аймаг/Нийслэл: Баянхонгор

Сум/Дүүрэг: Баян-Өндөр

Баг/Хороо: 1-р баг, Улаан үзүүр

Гудамж: өө

Хаяг сонгох

Байрны код

Байрыг давхцахгүй байдлаар системээс кодолж өгнө.

Байрны нэр

Байрыг хооронд нь ялгаатай байдлаар нэрлэнэ. Жич: Хичээлийн 1-р байр, Дотуур байр гэх мэт.

Үндсэн зориулалт

Байрны өөрийнх нь **үндсэн зориулалтыг** жагсаалтаас сонгоно. Сонголтоос ямар зориулалтыг сонгосноос шалтгаалж талбарууд өөрчлөгдөнө. Жич. Хичээлийн байр, дотуур байр гэх мэт.

Байрны төрөл

Байр эсвэл гэр гэсэн сонголтоос сонгоно.

Энэ нь гэр цэцэрлэгт үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд гэр төрлийг сонгоход ашиглагдана.

Хөрөнгийн код

Санхүү удирдлага системийн үндсэн хөрөнгөнд “Барилга, байгууламж” ангиллаар бүртгэсэн хөрөнгөөс тохирохыг сонгож оруулна.

Эзэмшлийн төрөл

Байрны эзэмшлийн төрлийг сонгоно. Өөрийн эзэмшил, бусдын эзэмшлийн аль нь болохыг сонгоно.

Ашиглалтад орсон огноо

Байрны ашиглалтад орсон огноог оруулна. Календариас сонгосноор формат зөрүүлж алдаа гаргахгүй.
Жич: 1982-01-01

Нийт эзлэхүүн (м3)

Байрны нийт эзлэхүүнийг бичнэ. Эзлэхүүнээр бичихийг анхаарна уу. Жич: 16075

Нийт талбай (м2)

Байрны нийт талбайг бичнэ. Жич: 64330

Ашигтай талбай (м2)

Байрны нийт ашигтай талбайг бичнэ. Жич: 6430 /Нийт талбайгаас бага байх ёстой.

Байрны нийт давхар

Байрны нийт давхрыг бичнэ. Жич: 2

Стандартын эсэх

Байр нь стандартын эсэхийг би

1.2. Байрны мэдээлэл засах

1.2. Байрны мэдээлэл засах

Байрны мэдээлэл засах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.

2. Үүссэн байрны жагсаалтаас **засах** байрыг сонгоно.

3. **Үйлдэл** цэсээс **байрны мэдээлэл засах** үйлдлийг дарна.

4. **Байрны мэдээлэл засах** цонхны мэдээллийг засаж, хадгална.

Системд бүртгэсэн байрны жагсаалтаас засах байрыг сонгоод шинэ байрны арын **доош харсан сум** дээр дарахад үйлдлийн жагсаалт гарах бөгөөд **байрны мэдээлэл засах** гэсэн үйлдлийг дарах эсвэл **байрны**

нэр дээр дарахад **байрны мэдээлэл засах** дараах цонх нээгдэнэ.

Байрны мэдээлэл засах цонхны талбарын мэдээллийг засаж **хадгалах** товчийг дарснаар таны засаж, өөрчилсөн мэдээлэл хадгалагдана. Талбар бүр дэх мэдээллийг өөрчилж, засах боломжтой.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА v1.3

Сургалтын орчин | **Байр** | Өрөө

Хайх | Дэлгэрэнгүй | Шинэ байр | Үйлдэл

№	Нэр	Үндсэн зориулалт	Ашиглалтанд орсон огноо	Хүчин чадал	Нэмэлт зориулалт
1	A1	Хичээлийн байр	1985-01-01	1440	
2	A2	Хичээлийн байр	1986-08-18	1693	

Байрны мэдээлэл засах
Байр устгах
Excel рүү гаргах

1.3. Байрны мэдээлэл устгах

1.3. Байрны мэдээлэл устгах

Байр устгах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.

2. Байрны жагсаалтаас **устгах** байрыг сонгоно.

3. **Үйлдэл** цэсээс **байр устгах** үйлдлийг дарна.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА v1.3

Сургалтын орчин | **Байр** | Өрөө

Хайх | Дэлгэрэнгүй | Шинэ байр | Үйлдэл

№	Нэр	Үндсэн зориулалт	Ашиглалтанд орсон огноо	Хүчин чадал	Нэмэлт зориулалт
1	A1	Хичээлийн байр	1985-01-01	1440	
2	A2	Хичээлийн байр	1986-08-18	1693	

Байрны мэдээлэл засах
Байр устгах
Excel рүү гаргах

Жагсаалтаас устгах байрыг сонгоод үйлдэл цэсээс **байр устгах** гэсэн үйлдлийг дарахад дараах дэд цонх

нээгдэнэ.

- **Үгүй**



Үгүй товчийг дарахад байр устгахгүй.

- **Тийм**

Тийм товчийг дарахад байр устана.

Анхааруулга

Хэрэв устгах товч дарсны дараа анхааруулга гэсэн цонх гарвал тухайн байранд байрлах өрөөг үүсгэсэн байна. Байранд байрлах өрөөг устгасны дараа тухайн байрыг устгах боломжтой.



1.4. Шинэ өрөө үүсгэх

1.4. Шинэ өрөө үүсгэх

Энэхүү үйлдлийг сургалтын үйл ажиллагаа явуулахад ашиглаж байгаа байрыг систем дээр үүсгэсний дараа түүнд байрлах өрөө бүрийг шинээр үүсгэхэд ашиглана.

Шинэ өрөө үүсгэхээс өмнө системд дараах үйлдлийг хийсэн байх ёстой.

Бүртгэх гэж буй өрөө байрлах **байрыг** БУС-ийн сургалтын орчин үйл ажиллагааны байр таб-д шинэ байр үйлдлээр бүртгэсэн байх. (нэмэлт зориулалтаар ашигладаг байрны өрөө, танхимыг бүртгэхээс өмнө тухайн бүртгэсэн байрны нэмэлт зориулалт хэсэгт уг байрыг бүртгэж өгсөн байх)

Шинэ өрөө үүсгэх үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

БУ системийн Сургалтын орчин үйл ажиллагааг сонгоно.

1.**Шинэ өрөө** үйлдлийг дарна.

2.**Шинэ өрөө** бүртгэлийн цонхны мэдээллийг оруулж хадгална.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Сургалтын орчин**-г сонгоход дараах цонх нээгдэнэ.

Баруун дээд хэсэгт байрлах **Шинэ өрөө** гэсэн үйлдлийг дарахад дараах бүртгэлийн цонх нээгдэнэ.

№	Байр	Тоот	Өрөөний нэр	Төрөл	Багтаамж	Эд хөрөнгө
1	Б3	113	Нийгмийн ажилтны өрөө	Нийгмийн ажилтны өрөө	2	Компьютер(2),Принтер(2),Сандал(5),Сканне...
2	Б3	217	Багш нарын өрөө	Багшийн өрөө	20	Богино долгионы зуух(1)Дэлгэц(1),Номын та...
3	Б3	217а	Сургалтын менежер1	Бусад ажилтны өрөө	1	Ангийн самбар(1),Багшийн сандал(1),Багший...
4	Б3	217б	Сургалтын менежерийн ...	Бусад ажилтны өрөө	1	Ангийн самбар(2),Багшийн ширээ (1),Дэлгэц(...
5	Б3	00	Ариун цэврийн өрөө	Ариун цэврийн өрөө/00/	5	Суултуур(5),Угаалтуур(5),Хогийн сав(5)
6	Б3	219	Гүйцэтгэх захирал	Захирлын өрөө	1	Ангийн самбар(1),Бусад цахилгаан хэрэгсэл(...
7	А2	220	Багшийн хөгжлийн өрөө	Бусад ажилтны өрөө	11	Ангийн самбар(1),Багшийн ширээ (1),Компью...
8	Б3	218	Номын сан	Номын сан	20	Ангийн самбар(2),Компьютер(1),Номын тави...
9	Б3	118	Няравын өрөө	Бусад ажилтны өрөө	5	Компьютер(1),Принтер(1),Сандал(1),Ширээ(1)
10	Б3	108	Хичээлийн танхим	Хичээлийн танхим	40	Ангийн самбар(2),Багшийн сандал(1),Багший...

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

Анги, танхим засах: Хими-1

Хадгалаад хаах

Байр: Хичээлийн 1-р байр
 Байрны зориулалт: Хичээлийн байр
 Анги, танхимын нэр: Хими-1
 Төрөл: Хичээлийн танхим
 Танхимын төрөл: Хими
 Байрлах давхар: 203
 Тоот: 2
 Багтаамж (хүнээр): 35
 Өндөр (м): 2.5

Урт (м): 5
 Өргөн (м): 2.8
 Давхцал шалгах эсэх:
 Гэрчилгээтэй эсэх:
 Гэрчилгээний дугаар: 0152002026
 Олгосон огноо: 2015-09-19
 Дуусах огноо: 2017-09-19
 Бүрэлдэхүүнтэй эсэх:

Бүрэлдэхүүн өрөө

Өрөө	Төрөл	Багтаамж
химийн арын өрөө	Химийн лаборатори	6

Эд хөрөнгө

Нэр	Тоо ширхэг
Сурагчийн сандал	35
Сурагчийн ширээ	35
Ангийн самбар	1
Багшийн ширээ	1
Багшийн сандал	1

Ашиглах боломжгүй цаг

Гарар	Эхлэх цаг	Дуусах цаг
-------	-----------	------------

•Байр

Бүртгэх өрөө байрлаж байгаа байрыг сонгоно. Жич: Хичээлийн 1-р байр.. (Хичээлийн 1-р байранд байрлаж байгаа өрөөг бүртгэх бол)

•Байрны зориулалт

Өрөө байрлаж байгаа байрны зориулалтыг сонгож өгнө. Жич: Хичээлийн байр

•Өрөөний нэр

Тухайн өрөөний нэрийг бичнэ. Жич: Математик-1

•Төрөл

Өрөөний төрлийг зөв сонгож өгнө. Өрөөний төрлийн сонголтоос хамаарч дараагийн бүртгэлийн талбарууд өөрчлөгдөнө. Хэрэв та хичээлийн **анги, танхим** өрөөг бүртгэх гэж байгаа бол **хичээлийн танхим** сонголтыг сонгож өгснөөр дараагийн бүртгэх талбарт хичээлийн танхимын төрлийг сонгох боломжтой болно. Жич: Хичээлийн танхим, биеийн тамирын заал...

•Танхимын төрөл

Төрөл талбарт **хичээлийн танхим** сонголт хийсэн бол энэхүү талбар гарах бөгөөд анги, танхимын жагсаалтаас бүртгэх **танхимын төрлийг** зөв сонгоно. Жич: Математик (энэ нь математикийн анги, танхим гэсэн үг юм.)

•Байрлах давхар

Өрөөний байрлаж байгаа давхрыг бичнэ. Жич: 2

• Тоот

Өрөөний дугаар тоотыг бичнэ. Жич: 203

•**Багтаамж (хүнээр)**

Өрөө хэдэн хүний багтаамжтайг бичнэ. Жич: 35

•**Өндөр (м)**

Өрөөний өндрийг метрээр бодож **тоо** бичнэ. Бутархай тоо бичих бол “**цэг**”-ээр авна. Жич: 2.8

•**Урт (м)**

Өрөөний уртыг метрээр бодож **тоо** бичнэ. Жич: 6

•**Өргөн (м)**

Өрөөний өргөнийг метрээр бодож **тоо** бичнэ. Жич: 5

• **Давхцал шалгах эсэх**

Давхцалыг шалгах бол тэмдэглэгээ хийнэ. (чеклэнэ) Давхцал шалгахгүй гэвэл тэмдэглэгээ хийхгүй (чеклэхгүй).

•**Гэрчилгээтэй эсэх**